

Биеийн тамирын багшийн мэргэжлийн ур чадварын онцлог*Б.Нармандах***МУБИС, Биеийн Тамирын Сургууль,
Биеийн тамир спортын онол, арга зүйн тэнхим***Хураангуй**

Энэхүү өгүүллээр орчин үеийн ажил олгогч нарын мэргэжилтнүүдэд тавигдаж буй шаардлагууд, болон биеийн тамирын багшийн мэргэжлийн ур чадваруудын асуудлыг хөндөж судалсан. Биеийн тамирын сургалтын үр дүн мэргэжлийн багшаас шууд шалтгаална гэж үзэж болно. Тиймээс биеийн тамирын багшийн мэргэжлийн ур чадварын асуудлыг судалсан судлаачдын бүтээлд шинжилгээ хийж, биеийн тамирын багшийн ур чадварын онцлогийг тодорхойлж гаргасан. Биеийн тамирын багш нь дидактик чадвар, харилцааны чадвар, академик чадвар, зохион байгуулах чадвар, таних, шинжих чадвар, хэл ярианы чадвар, хүртэхүйн чадваруудыг зайлшгүй эзэмших шаардлагатай бөгөөд эдгээрээс хамгийн чухал нь төрөл бүрийн спортын дасгалын техникийг суралцагчдад үзүүлэх, алдааг олж харах, тэдгээрийг засах чадварууд юм. Түүнчлэн мэргэжлийн ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх шаардлагатай.

Түлхүүр үг

Мэргэжлийн ур чадвар, хувийн чадвар, нийгмийн чадвар

Өнөөгийн мэдээлэл оюуны эрин зуунд цаг хугацаа хувьсан өөрчлөгдөхийн хэрээр хувь хүний эзэмшиж буй мэргэжилд өндөр шаардлага тавигдах боллоо. Хүн дуртай ажлаа хийж байхдаа л хамгийн аз жаргалтай байдаг. Тиймээс хүн сонирхсон мэргэжлээ сонгох нь хамгийн зөв. Гэвч зөвхөн дуртай, сонирхолтой байлаа гээд сайн мэргэжилтэн болох уу гэвэл бас үгүй юм. Ер нь мэргэжилтэн гэж тухайн ажлыг чанартай сайн гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг хандлага, туршлага, үнэт зүйлийг эзэмшсэн хүнийг хэлдэг ба аливаа ажил мэргэжлийн хувьд нэн чухал нэмэр болох чадварыг мэргэжлийн ур чадвар гэнэ.

Гадаад ур чадварт (hard skills) тухайн ажлыг хийхэд шаардагдах суурь чадвар багтдаг. Гадаад ур чадваруудыг хичээлээс, сургалтын материалууд дээр ажиллах үед, эсвэл ажиллах явцдаа эзэмшиж болдог буюу суралцах боломжтой байна. Жишээ нь гадаад хэлний мэдлэг, мэргэжлийн гэрчилгээт болон зэрэг, цол олгох сургалт, хурдан шивэх чадвар зэрэг. Эдгээрийг хувь хүн өөрийн танилцуулгад жагсаасан байх бөгөөд ажил олгогчид ажилтанг таних бололцоог олгодог. Харин дотоод ур чадвар нь эсрэгээр субъектив чадварууд юм. Дотоод ур чадварт (soft skills) хувь хүний хөгжлийн ур чадварууд багтах ба тухайн ажлыг хийхэд шаардах хувь хүний онцлог шинж, бүтээлч сэтгэлгээ, шийдвэр гаргалт, асуудал шийдвэрлэх чадвар, уян хатан байдал, манлайлал, хүсэл тэмүүлэл, цаг төлөвлөлт, ажлын ёс зүй, тэвчээртэй байх зэрэг ур чадварууд юм.

2016 онд Швейцарийн Давос хотноо зохион байгуулсан дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын үеэр технологийн эринд буюу 2020 онд хамгийн эрэлттэй байх мэргэжил ба түүнд шаардагдах ур чадваруудыг нэрлэсэн байна. Тэгэхээр ирээдүйд ямар ур чадвартай ажилтан үгүйлэгдэх вэ? гэсэн асуултаар ажил олгогчдоос судалгаа авахад хамгийн нэгдүгээрт Асуудлыг цогцоор нь шийдвэрлэх чадвар (complex problem solving)-ыг гол ур чадвар гэж 36 хувь нь үзсэн байна. Асуудлыг боловсруулах, үнэлэх, шийдлийг олох, хэрэгжүүлэх зэрэг аливаа асуудалд бүхий л талаас нь хандаж шинэ нөхцөлд тодорхой бус асуудлыг шийдвэрлэх чадвар хамгийн чухалд тооцогдож байна.

Ирээдүйн ажилтны эзэмших ур чадварын хоёрдугаарт Шүүмжлэлт сэтгэлгээ (critical thinking) буюу аливаа зүйлийн давуу ба сул талыг тодорхойлохын тулд логик үндэслэлийг ашиглаж, тооцоолох ур чадвар орно гэж үздэг. Бид аливаа зүйлийг эргэцүүлэхдээ янз бүрийн шийдлүүд, хандлагыг тус бүрд нь авч үзэн тэдний хоорондын логик холбоо шалтгааныг тодорхойлон шүүмжлэгч, сэтгэгч байх зайлшгүй шаардлагатай байна.

Бүтээлч сэтгэлгээ (creativity)-ний чадвар нь аливааг урьдчилан харах чадвар бөгөөд дээрх судалгаагаар гуравдугаарт эрэмбэлэгджээ. Шинэ технологийн дэвшил бүхийн эрин зуунд бүтээлч хүмүүс шинэ технологи нэвтрүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох арга замыг эрин сурвалжилж байна. Бид сониуч зан,

* ✉ b_narmandakh@msue.edu.mn

өөрийгөө илэрхийлэх чадвараа байнга хөгжүүлж өөрийн дотоод бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж байх зайлшгүй шаардлагатай.

Дөрөвдүгээрт, хүмүүсийг удирдах чадвар (People management) бол хүмүүсийг идэвхжүүлэх, хөгжүүлэх, ажилд хамгийн сайн хүнийг тодорхойлж, дэмжих чадвар юм. Хүмүүсийг удирдах чадвар тэдэнд урам зоригтой ажиллах нөхцөлийг бүрдүүлж тэдний хэрэгцээг мэдрэх, урамшуулах, бүтээлч сэтгэлгээг нь нээж өгөх байдлаар илэрнэ.

Тавдугаарт, бусадтай харилцах чадвар (Coordinating with others) Бусад хүмүүсийг ойлгох, өөрийгөө бусдад ойлгуулахад тус болдог чадварыг хэлнэ. Бид өдөр тутамдаа бусадтай харилцаж байдаг. Тиймээс бие биеийнхээ давуу болон сул талыг мэдэх, аливаа нөхцөл байдалд зохицон ажиллах чадвартай байх хэрэгтэй.

Зургаадугаарт, сэтгэл хөдлөл болон өөрийгөө удирдах чадвар (Emotional intelligence) Энэ чадвар нь өөрийн дотоод мэдрэмжээрээ бусдын зан авирыг таньж мэдэх, сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийг мэдрэх чадвар төдийгүй түүнд тохирсон арга хэмжээг авах, шийдвэр гаргах чадварыг илтгэх ба таны EQ (сэтгэл хөдлөл) эерэг үр дүнг нэмэгдүүлэх боломжтой.

Долоодугаарт, тунгаан бодох болон шийдвэр гаргах чадвар (Judgment and decision-making)

Энэхүү чадвар нь өгөгдөлд дүн шинжилгээ хийх, улмаар оновчтой шийдэл, шийдвэр гаргаж чаддаг байх чадвар ба амжилттай бүхэн оновчтой шийдвэрээс шалтгаалдаг.

Наймдугаарт, үйлчилгээний чиг хандлага (Service orientation) Энэхүү чадвар нь бусдын хэрэгцээг урьдчилан таамаглах, хүлээн зөвшөөрөх, хүмүүсийн сэтгэл хангалуун байдлыг хангаж өөрийгөө бусдад хүлээн зөвшөөрүүлэх чадвар юм.

Есдүгээрт, хэлэлцээр хийх чадвар (Negotiation) амжилттай хэлэлцээр хийх нь хоёр талыг нэгтгэх аль аль талдаа тохирсон гэрээ хийхийг шаарддаг ба хамтран ажиллахад нэгдмэл саналтай байх их чухал юм.

Аравдугаарт, танин мэдэхүйн уян хатан байдал (Cognitive flexibility). Танин мэдэхүйн уян хатан байдал нь аливааг хурдан шуурхай эргэцүүлэн бодох олон зүйлийг нэгэн зэрэг бодож тооцоолох чадвар юм. Энэхүү чадвар нь бүтээлч шүүмжлэлийг шаарддаг. Ямагт өөрийгөө шинэ зүйл сурахад зориулж шинэлэг арга барил, шинэ санаа дэвшүүлэх зэргээр ажиллаж чаддаг хүн бусдадаа шинэ гэрэл нээж өгнө.

Эдгээр ур чадварыг эзэмшсэн нэгэн ирээдүйд ажлын байрандаа үнэлэгдэх боломжтой.

Суралцагч тодорхой зүйлийг хийж сурахад хөтлөх үйлийг багшлах гэж үзвэл багшлах үйл ажиллагаа нь багшаас ур чадварыг шаардана. Энэ ур чадварыг сурган хүмүүжүүлэх ном зохиолд багшийн ур чадвар хэмээн нэрлэж, олон өнцгөөс тайлбарласан байна

С.В.Колотильщикова болон ОХУ-ын зарим судлаач биеийн тамирын багшийн мэргэжлийн ур чадварыг түүний сурган хүмүүжүүлэх авьяас чадвараар тодорхойлж болно гэж үзээд дараах бүлэг чадварыг нэрлэсэн байна. (2016, х.36) Үүнд:

- *Дидактикийн чадвар.* Энэ нь тодорхой бүлгийн сурагчдын бие бялдрын ялгаатай байдалд тохируулан сургалтын материалыг ойлгомжтой тайлбарлах, тэдний сонирхлыг өрнүүлж, биеийн тамирын хичээлд сэдэлжүүлэх, улмаар сурагчдын бие даан ажиллаж боломжийг дэмжин идэвхжүүлэх биеийн тамирын багшийн чадвар юм.
- *Академик мэдлэг, чадвар.* Энэ нь биеийн тамирын шинжлэх ухаанд хамаарах чадвар бөгөөд биеийн тамирын чадварлаг багш бол зөвхөн өөрийн хичээлийн хүрээнд бус, суралцагчдын бие бялдыг болон спортын авьяасыг нээн хөгжүүлэх өргөн хүрээний, гүн гүнзгий мэдлэгтэй, түүнийгээ ашиглах чадвартай байх ёстой. Тиймээс биеийн тамирын багш хүн биеийн тамир, спортын салбарт гарч буй шинжлэх ухааны ололт, нээлтийг танин мэдэх эрмэлзэлтэй, өөрөө судалгааны ажлыг хийдэг байвал зохино.
- *Хүртэхүйн чадвар.* Энэ нь суралцагчийн дотоод ертөнцөд нэвтрэн орж, түүний сэтгэл зүйн байдал, бие хүний сэтгэл зүйг мэдэрч ойлгох багшийн чадвар болно.
- *Хэл ярианы чадвар.* Биеийн тамирын багш нь мэргэжлийн үг яриа, нүүр царайны хувирал, гар ба биеийн хөдөлгөөнийг хослуулан өөрийн санааг тод томруун, ойлгомжтой илэрхийлэх чадвар юм. Ингэж ярихдаа багш өөртөө итгэлтэй, сонсогчийн сонирхлыг тагахуйц хүчтэй ярих хэрэгтэй байдаг.
- *Зохион байгуулах чадвар.* Сургалтын зорилгыг шийдвэрлэхдээ аюулгүй байдлыг ханган хэрэгжүүлэх, суралцагчдыг урамшуулан дэмжих, тэднийг хамт олонч болгон зохион байгуулах чадварыг биеийн тамирын багш эзэмшихийн зэрэгцээ багш өөрийн үйл ажиллагааг зохион байгуулах өндөр чадвартай байх ёстой.
- *Харилцаа холбоо тогтоох чадвар.* Энэ нь суралцагчидтай харилцахдаа зөв гарцыг олж, тэдэнтэй ойр, нягт холбоотой байж

сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа явуулах багшийн чадвар юм. Спортын хурц ширүүн өрсөлдөөний үед ч эрүүл, зөв харилцааг эрхэмлэдэг байх ёстой.

- *Сурган хүмүүжүүлэх төсөөллийн чадвар.* Энэ нь суралцагчдын бие бялдрын аль ч чадавхын хөгжлийг урьдаас төсөөлөх буюу тухайн сурагчаас “юу авч болох”-ыг таах чадвар бөгөөд биеийн тамирын багшид чухал хэрэгцээт чадвар мөн.
- *Анхаарлаа хуваарилах чадвар.* Үүнийг хэд хэдэн төрлийн үйл ажиллагаанд нэгэн зэрэг анхаарлаа хуваарилах багшийн чадвар гэж үзнэ. Биеийн тамирын багш зааж буй дасгалынхаа агуулга, хэлбэрийг анхаарах, сурагчийн авч буй бие бялдрын ачааллыг хянах, ядралтын шинж тэмдэг илэрвэл ачааллыг зохицуулах, бүх сурагчийн аюулгүй байдлыг хангах, ойлгохгүй байгаа зүйлийг ойлгуулах, сурагчдыг сахилга багтай байлгах, тэдний зан байдлыг удирдах зэрэг олон үйл ажиллагааг явуулна. Гэхдээ энд багшийн анхаарлаа хандуулах бүх зүйлсийг бүрэн тоочоогүй болно.

Судлаач Б.А.Ашмарин биеийн тамирын багш мэргэжлийн чадварыг дараах 5 багц чадварт хувааж тайлбарласан. (1978, с.375) Үүнд: багшийн зохион бүтээх чадвар, зохион байгуулах чадвар, хүртэхүйн чадвар, харилцааны ба дидактикийн чадвар, хөдөлгөөний чадвар багтах бөгөөд түүний энэ ангилал өнөөдөр ч ач холбогдлоо хадгалсаар байна.

В.А.Сластенин - биеийн тамирын багшийн мэргэшил (профессионализм) гэдэг нь “сурган хүмүүжүүлэх зорилтыг бүтээгдэхүүн болгож шийдвэрлэх мэргэжлийн чадамжийн дээд түвшинг илэрхийлэх чанарын шинж” хэмээн тэмдэглээд профессионализмын дор биеийн тамирын багш бие хүний мэргэжлийн үйл ажиллагаандаа нарийн мэргэшсэн байдал, мэргэжлийн боловсролын түвшин зэргийг хамруулсан байна.

Биеийн тамирын багшийн сурган хүмүүжүүлэх ур чадвар ба сурган хүмүүжүүлэх урлаг гэсэн ойлголтууд нэг ижил санааг илэрхийлнэ. Эдгээр ойлголт нь багш мэргэжлийн олон талт үйл ажиллагааны мэдлэг, чадвар, дадлыг цогцоор эзэмшиж, сайжруулахтай холбоотой юм. Түүнчлэн сурган хүмүүжүүлэх чадвар гэдэг нь биеийн тамирын багшийн практик үйл ажиллагааны нэгдлийг голчлон харуулдаг бол, сурган хүмүүжүүлэх техник ба арга зүй нь биеийн тамирын сургалтын арга, хэрэглүүрийг иж бүрнээр ашиглах, дуу хоолой, биеийн хөдөлгөөн,

нүүрний хувирал зэргээ хооронд нь зохицуулах чадварыг багтаасан ойлголт болох нь мэргэжлийн ном зохиолуудаас харагдаж байна. Эдгээрийг нэгтгэж үзвэл биеийн тамирын багшийн сурган хүмүүжүүлэх ур чадварыг 1-р бүдүүвчээс харж болохоор байна.

Бүдүүвч 1

Биеийн тамирын багшийн сурган хүмүүжүүлэх ур чадварын бүтэц



Биеийн тамирын багшийн зохион бүтээх чадвар нь багш үйл ажиллагаагаа төлөвлөхөд тусалдаг бөгөөд сургалтыг төлөвлөх, агуулгыг сонгох (жишээ нь, суралцагчдын хурдны чадавхыг хөгжүүлэх иж бүрэн дасгал зохиох, тэдний анхаарлыг татах үйл ажиллагааг төлөвлөх), хэтийн ба явцын төлөвлөлтийг хэрэгжүүлэх, спортын хэрэглэл, биеийн тамирын сургалтын хэрэглэгдэхүүнийг засаж сэлбэх, олж нийлүүлэх чадвар энд хамаарна.

Биеийн тамирын багшид зохион байгуулах чадвар чухал юм. Багш хичээлээ сайн төлөвлөсөн ч зохион байгуулалт тааруу бол хичээлийн үр дүн буурах нь тодорхой. Эсрэгээрээ биеийн тамирын багш мэргэжлээр суралцагч оюутнууд биеийн тамирын хичээлийг зохион байгуулах мэдлэг, чадвар дутмаг байвал сурагчдыг удирдах боломжгүй болно. Сурагчдыг зохион байгуулахаас гадна өөрийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чадвар биеийн тамирын багшид зайлшгүй хэрэгтэй. Багш бүрт энэ чадвар харилцан адилгүй байдаг. Мэдрэлийн тогтолцооны эрч хүчтэй багш бол тодорхой нэг тохиолдлоос өөр нөхцөлд шилжихдээ хувийн зохион байгуулалт өндөртэй байж чадахын зэрэгцээ тэд ажлын цагаа сайн зохицуулж, хичээлийн үед биеийн тамирын зааланд тохиромжтой байрыг эзлэн, өөртөө туслах сурагчдыг зөв сонгож ажиллуулж чаддаг.

Зохион байгуулах чадварыг сайн эзэмшсэн багш биеийн тамирын хичээл болон спортын секц, тэмцээн уралдаан, биеийн тамирын баяр наадам, хөдөлгөөнт тоглоом, буухиа уралдааныг ч зохион байгуулахдаа их идэвхтэй оролцож, суралцагчдыг зөв удирдаж чадна.

Биеийн тамирын багшийн зохион байгуулах чадвар янз бүрээр илэрдэг байна. Үүнд:

- Хичээлийн ба дасгалын зорилгыг тайлбарлах, команд өгөх, сурагчдыг жагсаах, хичээлийг дүгнэх үед багшийн хэл ярианы чадвараар илэрнэ.
- Хичээл явуулах заал талбайг сонгож бэлтгэх, олон сурагчаар дасгал гүйцэтгүүлэх, хамгаалалт туслалцаа үзүүлэх, сурагчдыг сахилга багтай байлгах, сургалтын хэрэглэгдэхүүнийг тарааж өгөх, хураах зэрэг үйл ажиллагааны үед багшийн зан байдлаар илэрнэ.
- Хичээлд сурагчдыг идэвхжүүлэх, хичээлийн агуулгыг эзэмшүүлэх, дасгал гүйцэтгэх аргыг сонгох, сурагчдын мэдлэг, чадварыг үнэлж дүгнэх зэрэг үед багшийн удирдах чадвараар илэрнэ.

Багшаас сурагчидтай, ажлын хамт олонтойгоо, эцэг эхчүүдтэй харилцах арга замыг олох, хамтын хүрээллийг бий болгох чадвар нь биеийн тамирын багшийн харилцааны чадварыг илэрхийлэх бөгөөд үүнийг дотор нь: хүнтэй холбоо тогтоох ба уран үгийн чадвар гэж хуваасан байдаг. Багшийн ярианы соёл нь харилцааны үр дүнг дээшлүүлэхэд чухал нөлөөтэй.

Биеийн тамирын багшийн дидактик чадвар нь суралцагчдад сургалтын материалыг эзэмшүүлэхтэй холбоотой чадвар юм. Үүнд: бие бялдрын дасгалаар хичээллэх сонирхлыг өдөөх, нарийн түвэгтэй дасгалыг өөрийн биеэр үзүүлж, түүнийг амжилттай гүйцэтгэж чадна гэсэн итгэлийг сурагчдад төрүүлэх, сурагчдын анхаарлыг жолоодох, өөрийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны үр дагаврыг урьдчилан тооцоолох чадварууд багтана. Багшийн энэ чадвар: биеийн тамирын хичээл дээрх багшийн үг яриагаар болон мэдээллийн чанарыг өндөрсгөх хөдөлгөөнөөр (гимнастикийн дасгалыг уран гоё гүйцэтгэхийг итгүүлэхдээ нүүрэндээ инээмсэглэл тодруулан, цээжээ тэвхийлгэн хөдөлгөх гэх мэт) ч илэрч болно.

Багшийн *таних чадвар* гэдэгт өөрийн үйл ажиллагааны амжилт, сурган хүмүүжүүлэх нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх замаар тодорхой сурагчийн болон анги хамт олны суралцах хэв маяг, шинж чанарыг шинжих чадварыг авч үзнэ.

Энэ чадвар нь хүртэхүйн чадварт суурилах бөгөөд ажиглах, анзаарах чадвараар илэрнэ. Түүнчлэн сургалт – арга зүйн болон судалгаа шинжилгээний ном бүтээлийг ашиглах, энгийн судалгаа явуулах, судалгааны үр дүнд задлан шинжилгээ хийх чадварууд энд хамаарагдана.

Биеийн тамирын багшийн *хөдөлгөөний чадвар* нь юуны өмнө бие бялдрын дасгалын техникийг гүйцэтгэх чадварыг харуулна. Сургалтын хөтөлбөрт багтсан бие бялдрын ямар нэг дасгалыг багш зөв үзүүлэх нь биеийн тамирын сургалтад суралцагчдын оролцоог нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй. Түүнчлэн биеийн тамирын багшийн энэ чадварт дасгалыг гүйцэтгэх үед сурагчдыг хамгаалах, туслалцаа дэмжлэг үзүүлэх чадварыг хамруулж үздэг.

Багш нартай хийсэн ярилцлага болон дээрх бүтээлүүдээс дүгнэж үзвэл биеийн тамирын багш ерөнхий боловсролын сургуульд багшлах гайгүй ур чадвартай болохын тулд наад зах нь 5-6 жил хэрэгтэй байна. Түүнээс хойш багш ур чадвараа мэргэжлийн түвшинд сайжруулах, улам хөгжүүлэх үйл явц үргэлжилнэ. Багшийн нас ахихын хирээр түүний бие бялдрын бэлтгэлжилт буурч, биеийн тамирын багшийн үйл ажиллагааны бүтцэд өөрчлөлт орно. Энэ нь суралцагчдаас өөртөө туслагчийг бэлтгэх, ялангуяа хөдөлгөөний гоо сайхныг бууруулахгүйгээр дасгалыг үзүүлэх сурагчийг сонгож, хичээл дээр түүний үзүүлэлтийг ашиглах чадвараар илэрнэ. Ингэснээр биеийн тамирын багшийн мэргэжлийн ур чадвар нь динамик шинжтэй өөрчлөгддөг болох нь тодорхой болно. Гэхдээ багш ур чадвараа тасралтгүй хөгжүүлнэ. Залуу багш, ялангуяа гарааны биеийн тамирын багш бол бие бялдрын дасгалыг заавал өөрийн биеэр сайн гүйцэтгэх чадвартай байх шаардлагатай.

Биеийн тамирын судлаачдын (Сластенин, В.А. 2004, с.18) үзэж буйгаар биеийн тамирын багш мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх дараах арга зам байна. Үүнд:

- Туршлагагай багшийн хичээлийг ажиглах,
- Мэргэжлийн ном, сэтгүүл унших,
- Спортын нэвтрүүлэг ба тэмцээн үзэх, спортын үйл явдал, арга хэмжээнд оролцох. Ингэхгүйгээр биеийн тамирын хичээл, спортын секцийг тохиромжтой сэтгэл хөдлөлөөр удирдаж чадахгүй юм.
- Өөрийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд өдөр тутам дүн шинжилгээ хийх. Үүнд: ангийг бүхэлд нь болон тодорхой сурагчийн онцлогийг тэмдэглэх, янз бүрийн тохиолдолд сурагчийн үйл

ажиллагаанд илэрсэн үр дүнг тодорхойлж зураглах, хичээлийн зохион байгуулалтын шинэ санаагаа бичих, ирээдүйн төлөвлөгөө боловсруулах зэрэг багтана.

- Биеийн тамирын багшийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдох, сонирхол татаж буй асуудлаар хэцүү биш судалгаа явуулах. Жишээ нь: ямар дасгалаар сурагчийн хүчийг хөгжүүлж болох вэ?, тодорхой насны хүүхдийн хурдны чадавхын түвшин ямар байна вэ?, тодорхой нөхцөлд ямар арга ашиглавал илүү үр дүнд хүрэх вэ? гэх мэт асуултад хариу болох судалгааны ажлыг гүйцэтгэх нь багшийн ур чадварын хөгжилд их ач холбогдолтой байна.
- Орчин үеийн багш сурган хүмүүжүүлэх зүй, сэтгэл судлал, физиологи болон биеийн тамирын онолын мэдлэгээ байнга шинэчилж, суралцагчдын бие бялдрыг хөгжүүлэх үр дүнтэй арга, хэрэглүүрийг эрж хайн, өөрийгөө хөгжүүлэх хэрэгтэй.

Дүгнэлт

Биеийн тамирын багшийн мэргэжлийг түүний ур чадвараар тодорхойлж болох бөгөөд үүний чухал шалгуурын нэг нь багшийн ажлын үр дүн байна. Суралцагчдын бие бялдрыг хөгжүүлж, эрүүл мэндийг бэхжүүлэх зорилгыг зөвхөн танхимын сургалтаар хэрэгжүүлэх боломж аль ч улсад бүрэн төгс биш байна. Иймээс суралцагч бага ангиасаа эхлэн идэвхтэй хөдөлгөөнийг ахуй амьдралдаа ашиглан, биеийн тамирын дасгалаар тогтмол хичээллэх дадал хэвшилтэй болгоход

биеийн тамирын сургалт чиглэх ёстой. Тэд ЕБС төгсөхдөө насан туршдаа тасралтгүй суралцан, бүтээлчээр ажиллаж, чанартай амьдрахад зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн түвшин, бие бялдрын хөгжил олж авах ба улмаар өөрийгөө хөгжүүлэх арга барил эзэмшүүлэхээр биеийн тамирын сургалтыг зохион байгуулахыг чухалчилж байна. Орчин үеийн нийгмийн оюун санааны үнэт зүйлийн нэг болсон багш-мэргэжилтний ур чадвар нь суралцагч болон тэдний эцэг эхийн санааг зовоодог асуудлын нэг юм. Суралцагч бүрийг биеийн тамирын хичээлд дуртай болгож, нэг ч хүүхдийг хоцроохгүйгээр хөгжүүлж чадсан багш л хамгийн ур чадвартайд тооцогдоно.

Ашигласан материал

- Ашмарин, Б.А. (1978). Теория и методика физического воспитания. Москва: Физкультура и спорт.
- Колотильщикова, С.В. (2016). Из чего складывается профессиональное мастерство учителя физической культуры.
- Сластенин, В.А. (2004). Профессионализм учителя как явление педагогической культуры. Педагогическое образование и наука. № 5.
- Arkininstall, M et al. (2010) *VCE Physical Education 2*. p.24-54. Malaysia: Macmillian
- <https://www.weforum.org/agenda/2016/01/the-10-skills-you-need-to-thrive-in-the-fourth-industrial-revolution/>

The characteristics of professional skills for physical education teacher

B.Narmandakh

Mongolian National University of Education

School of Physical Education, Department of Theory and Methodology of Sports

Abstract

Due to the issues about requirements for specialists as modern employers and their professional skills, physical education teachers were studied in this study. It can be considered that training results of physical education directly depends on professional teachers. Thus, features of physical education teacher were described in the way of making an analysis on researchers' works on the issues about professional skills for physical education teacher. It is necessary that physical education teacher must acquire those skills such as didactic, communication, academic, organizational, recognition, analytical skills, speaking and reflective skills. The most important one among them is skills to perform all kinds of sports, to work out techniques to the students, to find mistakes and to fix them. In addition, it is required to develop professional skills continuously.

Keywords

Professional skills, hard skills, soft skills